



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 2/124

Улаанбаатар хот

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн
хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр тооцох,
нөхөн төлбөр хийх гэрээний загвар шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйл, Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр тооцох, гэрээ хийх хяналтын хуудасны загварыг 1 дүгээр хавсралтаар, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай гэрээний загварыг 2 дугаар хавсралтаар, нөхөн төлбөрийн хуваарь, төлөлт тэмдэглэх хуудасны загварыг 3 дугаар хавсралтаар, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай гэрээ дүгнэсэн акт үйлдэх загварыг 4 дүгээр хавсралтаар, Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай гэрээний хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алдангийн тооцооллыг 5 дугаар хавсралтаар, Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай гэрээний хугацааг сунгах, нөхөн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах загварыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалд ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан зардлын тооцоонд хяналт тавих, нөхөн төлбөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн хэлтсийн (Т.Зууннаст)-т даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирлагын газрын (Ш.Ганхуяг) -т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/149 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БАЯРМАНДАЛ



1524101133

Ашигт малтмал, газрын төсны газрын даргын
2024 оны .11. дугаар/дүгээр сарын 27-ны/ний өдрийн
2/124... дугаар/дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫН
НӨХӨН ТӨЛБӨР ТООЦОХ, ГЭРЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аж ахуйн нэгжийн нэр: "....." ХХК

Бүртгэлийн дугаар:

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-

Талбайн хэмжээ: га

Хяналтын хуудас нээсэн: 20 оны ... сарын өдөр

УУХ-ий нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн: / /

№	Хянах үе шат	Тэмдэглэл, гаргасан дүгнэлт, шийдвэр	Хүлээлцсэн тухай баталгаажуулалт
1	Тухайн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах тайлангийн шүүлт		УГА-ны ГБТА-ын архивын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн хүлээн авсан: ... / ... / ... хүлээлгэн өгсөн: ... / ... / ... гарын үсэг нэр:
2	Нөхөн төлбөрийн тооцоолол, гэрээний төсөл боловсруулалт		Нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн хүлээн авсан: ... / ... / ... хүлээлгэн өгсөн: ... / ... / ... гарын үсэг нэр:
3	Нөхөн төлбөрийн тооцооллын хяналт		УУХ-ийн Ахлах мэргэжилтэн хүлээн авсан: ... / ... / ... хүлээлгэн өгсөн: ... / ... / ... гарын үсэг нэр:
4	Нөхөн төлбөрийн гэрээний хяналт		ХЭЗХ-ийн Ахлах мэргэжилтэн хүлээн авсан: ... / ... / ... хүлээлгэн өгсөн: ... / ... / ... гарын үсэг нэр:
5	Нөхөн төлбөрийн дүн, төлөлтийн хуваарийн баталгаажуулалт		УУХ-ийн дарга хүлээн авсан: ... / ... / ... хүлээлгэн өгсөн: ... / ... / ... гарын үсэг нэр:

	Нөхөн төлбөрийн гэрээний төслийн баталгаажуулалт		ХЭЗХ-ийн дарга хүлээн авсан: ... / ... / ... хүлээлгэн өгсөн: ... / ... / ... гарын үсэг нэр:
--	--	--	---

Жич: Энэхүү танилцах хуудсанд нөхөн төлбөрийн тооцооллыг заавал
хавсаргах ба хавсралтгүй бол хүчингүй!

Байгуулсан гэрээний дугаар: **ХА3-20**...../...../

Хяналтын хуудас хаасан: 20 оны ... сарын өдөр

УУХ-ий нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн: / /

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2024 оны 11 дугаар/дүгээр сарын 27-ны/ний өдрийн
11/24 дугаар/дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



БАТЛАВ:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/...../

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ТУХАЙ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын-ны өдөр

дугаар ХАЗ-20...../...../.....

Улаанбаатар
хот

Ерөнхий зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйл, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Нэг талаас Ашигт малтмал, газрын тосны газар /цаашид төрийн захиргааны байгууллага гэх/, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-..... тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй тоот гэрчилгээ, тоот регистрийн дугаартай ХХК /цаашид аж ахуйн нэгж гэх/ нь Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн аймгийн сумын нутаг дахь нэртэй ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, бүх шатны хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуулын ажлын зардлын нийт хэмжээ

1.1. аймгийн сумын нутаг дахь нэртэй орд дээр байрлах MV- тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд онд улсын төсвийн хөрөнгөөр нийт төгрөгийн зардал гарсан бөгөөд ногдох хэмжээг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход нийт нөхөн төлбөрийн хэмжээ төгрөг болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлийн 1.1.-д заасан нөхөн төлбөрийг ... жилийн хугацаанд доорх хуваарийн дагуу төлнө.

20... онд төгрөг / төгрөг мөнгө /
(тоогоор) (үсгээр)

20... онд төгрөг / төгрөг мөнгө /
(тоогоор) (үсгээр)

2.2. Энэхүү гэрээний Хоёрдугаар зүйлийн 2.1-д дурдсан онуудад хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд Хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны Ашигт малтмал, газрын тосны газрын төгрөгийн 100900000722 дугаартай Нөхөн төлбөрийн дансанд төлнө. Төлбөр төлөх гүйлгээний утга хэсэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар, он, улирал, сар, өдрийг тодорхой дэлгэрэнгүй бичнэ.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлбөрөө бүрэн төлж төлбөрийн баримтыг төрийн захиргааны байгууллагаар хянуулж гэрээнд хавсаргасан төлбөрийн хуваарь, төлөлт тэмдэглэх хуудаст тэмдэглэл хийлгэн санхүүгийн тэмдэг даруулж баталгаажуулна.

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн улирлын төлбөрийг тухайн улиралдаа багтаан төлөөгүй, түүнчлэн 4 улирлын төлбөрийг тухайн оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор төлөөгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн улиралд төлбөл зохих төлөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

2.5. Аж ахуйн нэгж нь эзэмшиж буй тусгай зөвшөөрлөө гуравдагч этгээдэд шилжүүлэх тохиолдолд шилжүүлэн авч буй аж ахуйн нэгжид энэхүү гэрээний үүргийг ч мөн шилжүүлж болох ба шилжүүлсэн тохиолдолд энэ тухайгаа төрийн захиргааны байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

Гурав. Ашигт малтмал, газрын тосны газрын хүлээх үүрэг, эрх

3.1. Энэхүү гэрээний 1.1-д заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд аливаа эрх зүйн үндэслэлгүйгээр өөрийн санаачилгаар өөрчлөхгүй.

3.2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банканд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3.3. Нөхөн төлбөр төлсөн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв төлсөн эсэхийг тухай бүр хянаж, гэрээний хавсралтад төлбөр төлсөн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Төрийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2. Энэхүү гэрээний Хоёрдугаар зүйлийн 2.2 дахь заалтын биелэлтийг төрийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж хамтран дүгнэж акт үйлдэнэ.

4.3. Гэрээг адил хүчинтэй 3 хувь үйлдэж нэг хувийг төрийн захиргааны байгууллага, нэг хувийг салбарын хяналтыни газар, нэг хувийг аж ахуйн нэгж тус тус хадгална. Гэрээнд нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажилд улсын төсвөөс гарсан зардлын тооцоолол, хяналтын хуудас, төлбөрийн хуваарь бүхий тэмдэглэлийн хуудас хавсаргах ба эдгээр нь гэрээний салшгүй нэг хэсэг болох бөгөөд хавсралтгүй бол гэрээ хүчингүй.

4.4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд төрийн захиргааны байгууллага шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

4.5. Тодорхой үндэслэл бүхий шалтгаанаар тухайн жилд үйлдвэрлэсэн болон ойрын жилүүдэд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ өөрчлөгдөх, хууль эрх зүйн үндэслэл бүхий хүндэтгэн үзэх шалгааны улмаас аж ахуй нэгж санал гаргасан тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.6 дахь заалтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхөн төлбөрийн хэмжээг багасгахгүйгээр, нэмэгдүүлж болох бөгөөд мөн хугацааг сунгаж нөхөн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулж болно.

Тав. Давагдашгүй хүчин зүйл

5.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд уг нөхцөлөөс шалтгаалан үүргээ биелүүлээгүй талыг буруутай гэж үзэхгүй.

5.2. Энэхүү гэрээний 5.1-д заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд талууд даруй харилцан мэдэгдэж шийдвэрлэх арга замыг тодорхойлно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ашигт малтмал, газрын тосны газрыг
төлөөлж:

Хайгуул, ашиглалтын газрын дарга

.....
/...../

Хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р
хороо, Барилгачдын талбай-3, Засгийн
газрын XII байр

Утас:

E-mail: info@mram.gov.mn

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг
төлөөлж:

“.....” ХХК-ийн
ерөнхий захирал

..... /...../

Хаяг:

..... аймаг/хот/
..... сум/дүүрэг/,-р
баг/хороо, байр

Утас:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2024 оны 11 дугаар/дүгээр сарын 17 ны/ний өдрийн
№/124.. дугаар/дүгээр тушаалын гуравдугаар хавсралт



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫГ
НӨХӨН ТӨЛӨХ ТУХАЙ ХАЗ-20..../...../..... ТООТ ГЭРЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ, ТӨЛӨЛТ ТЭМДЭГЛЭХ ХУУДАС**

Он	Улирал	Төлбөл зохиx	Төлсөн	Алданги	Төлбөр хийсэн огноо, баталгаажуулалт

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2024 оны 11 дугаар/дүгээр сарын 27-ны/ний өдрийн
2/124 дугаар/дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН
ЗАРДЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ТУХАЙ ХАЗ-20...../...../ ТООТ ГЭРЭЭГ
ДҮГНЭСЭН АКТ**

20 ... он ... сар ... өдөр

№20 ... / ...

Улаанбаатар хот

..... аймгийн сумын нутагт орших ордын ашигт малтмалын тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “.....” ХХК (улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:, регистрийн дугаар:) нь Ашигт малтмал, газрын тосны газартай оны ... дүгээр сарын ...-ны өдөр “Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай” ХАЗ-20...../...../..... тоот гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн дагуу байгуулсан ба тус гэрээний биелэлтийг талууд хамтран доорх байдлаар дүгнэв.

1. Тус гэрээний Нэгдүгээр зүйлийн 1.1.-д “Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардалд ашигт малтмалын ордын нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын тухайн талбайд ногдох зардал, хайгуулын бүх шатны ажилд улсын төсвөөс гаргасан зардлын нөхөн төлбөр”-ийг нийт төгрөг байхаар харилцан хүлээн зөвшөөрсөн байна.

2. Үүнээс ХХК нь гэрээний 2.1.-д заасан ... дахь төлөлтийг хугацаа хэтрүүлэлгүй төлсөн байна.

Харин ХХК нь гэрээний 2.1.-д заасан оны дугаар улиралд төлөх хуваарьтай байсан /...../ төгрөгийг оны ... дугаар сарын ...-ны өдөр төлсөн нь хуваарьт хугацаанаас хоног хэтэрсэн байна. (Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алданги төлсөн бол)

Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн хэлтсээс Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.7-д заасны дагуу буюу энэхүү актын Хавсралт 1-д харуулсан тооцооллыг “.....” ХХК-д хүргүүлж харилцан зөвшөөрсний үндсэн дээр нөхөн төлбөрийн хугацаа хэтэрсэн төлбөрийн алданги болох /...../ -ийг оны дүгээр сарын ...-ны өдөр төлүүлсэн болно. (Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алданги төлсөн бол)

3. Ингэснээр ХАЗ-20...../...../..... тоот гэрээний хугацаа, төлбөр тооцоотой холбогдох заалтууд хангагдаж /...../, түүн дээр хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алданги /...../ буюу нийлбэр дүнгээр /...../ -ийг улсын төсөвт төлөгдөв

Гэрээний талуудын эрх үүргийг тусгасан зүйл, заалтуудын биелэлт Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хангагдаж, талуудын хооронд аливаа маргаан үүсээгүйн дээр давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээний биелэлт хангагдаагүй тохиолдол гараагүй тул гэрээний хугацааг дуусгавар болгож гэрээ дүгнэсэн актыг адил хүчинтэй 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.

Энэхүү актад дараах нэр төрлийн хуудас материалыг хавсаргав.
Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай ХАЗ-20...../...../..... тоот гэрээ /....хуудас/
2. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр тооцох, гэрээ хийх хяналтын хуудас /....хуудас/
3. Тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөхөн төлбөрийн судалгаа, зардлын тооцоо /.... хуудас/
4. АМГТГ-ын мөнгөн гүйлгээний журнал /....хуудас/
5. Гэрээний 2.1.-д заасан төлбөр төлсөн баримтын хуулбар /....хуудас/
6. Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алдангийн тооцоолол /.... хуудас/ (Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алданги төлсөн бол)
7. Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алданги төлсөн баримтын хуулбар /....хуудас/ (Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн алданги төлсөн бол)

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Ашигт малтмал, газрын тосны газрыг
төлөөлж:

Уул уурхайн хэлтсийн дарга

..... /...../

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг
төлөөлж:

“.....” ХХК-ийн
ерөнхий захирал

..... /...../

Нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн

..... /...../

Хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р
хороо, Барилгачдын талбай-3, Засгийн
газрын XII байр
Утас:

Хаяг:

..... аймаг/хот/,
..... сум/дүүрэг/,-р
баг/хороо, байр
Утас:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2024 оны 11. дугаар/дүгээр сарын 7-ны ний өдрийн
А/124. дугаар/дүгээр тушаалын тавдугаар хавсралт



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ХАЙГУУЛЫН
АЖЛЫН ЗАРДЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ
ХУГАЦАА ХЭТЭРСЭН ТӨЛӨӨГҮЙ ТӨЛБӨРИЙН АЛДАНГИЙН
ТООЦООЛОЛ**

Гэрээний дугаар: **ХА3-20.../.../...**

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Хуваарьт төлбөртөлөх байсан он	Хугацаа хэтэрсэн төлөөгүй төлбөрийн үнийн дүн, төг	Хугацаа хэтэрсэн хоног	Хоногт төлөх алданги, төг	Нийт төлбөл зохих төлөөгүй төлбөрт ногдох алданги, төг
1	MV-.....	20..				
	MV-.....	20..				
	MV-.....	20..				
	MV-.....	20..				
	MV-.....	20..				
	Нийт:					

Тайлбар: Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.7-д заасны дагуу улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх гэрээний 3.4 дэх заалтаар хугацаа хэтэрсэн хоногт тутамд тухайн улиралд төлбөл зохих үнийн дүнгийн 0.1 хувиар тооцов.

Тооцоолол гаргасан:

Хүлээн зөвшөөрсөн:

Нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтэн

“.....” ХХК-ийн захирал

..... /...../

..... /...../

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2024 оны 11 дугаар/дүгээр сарын 17-ны/ний өдрийн
А/124 дугаар/дүгээр тушаалын зургадугаар хавсралт



БАТЛАВ:
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /...../

“.....” ХХК-ИЙН УЛСЫН ТӨСВӨӨС
ХАЙГУУЛЫН АЖИЛД ГАРСАН ЗАРДЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ХАЗ-...../.../... ТООТ
ГЭРЭЭНИЙ ХУГАЦААГ СУНГАХ, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХУВААРЬТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ХАВСРАЛТ

20../.../... Улаанбаатар хот

“.....” ХХК нь аймгийн
..... сумын нутагт орших ордын
MV-..... тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ажлын зардлыг нөхөн төлбөрийн ХАЗ-
...../.../... тоот гэрээнд өөрчлөлт Ашигт малтмал, газрын тосны газар-тай 20... оны ...
дугаар сарын ...-ны өдөр оруулж байгуулсан.

-Тайлбар үндэслэл
-

“.....” ХХК Улсын төсвөөс хайгуулын
ажилд гарсан зардлыг нөхөн төлөх тухай ХАЗ-...../.../... тоот гэрээний 2.1 дэх хэсэгт
заасан хуваарьт хугацаанд дараах өөрчлөлтийг оруулж байна.

Он, сар	Төлбөл зохих төлбөр төгрөг /ам доллар	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр	Бусад

Дээрх заасан хугацаанд нөхөн төлбөрийг алдангийн хамт багтаан төлж
барагдуулах, энэ хугацаанаас хэтэрвэл Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар
зүйлийн 60.7-д заасны дагуу алданги тооцож, эсвэл хуулийн 60.9 дэх хэсэгт заасны
дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах болохыг хоёр тал тохиролцов.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн ХАЗ-...../.../... тоот
гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТЫГ БАТАЛГААЖУУЛСАН:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙГ
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ: ТӨЛӨӨЛЖ:

ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

“.....” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

.....С.ГАН-ОЧИР

.....